

**БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ
ЗАСАГЛАЛЫН ТАЙЛАН**

2023

InvesCore
САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГА

Агуулга

Гүйцэтгэх захирлын мэндчилгээ	3
2023 оны гол үр дүнгүүд	4
БОНЗ он цагийн хэлхээ	5
Хамтын ажиллагаа	6
БОНЗ бүтэц	7
Ёс зүй ба комплаенс	8
БОНЗ бодлого	9
Байгаль орчин, нийгмийн эрсдэлийн удирдлага	10
Цахим үйлчилгээ	11
Роскет цахим зээлийн үйлчилгээ	12
Харилцагчийн үйлчилгээ	13
Нийгмийн хариуцлага	14
Жендерийн эрх тэгш байдал	15
Эмэгтэй ахлах ажилтнуудад зориулсан менторшип хөтөлбөр	16
Эмэгтэй бизнес эрхлэгчдийг дэмжих зээл	17
Ногоон оффис	18
Хариуцлагатай хэрэглээ	19
Ажилтнуудын сэтгэл ханамж ба эрүүл мэнд	20
Мэдээллийн аюулгүй байдал	21
Тогтвортой хөгжилд Инвескор 2023	22
Тогтвортой хөгжлийн алсын хараа	23



Гүйцэтгэх захирлын мэндчилгээ



Эрхэм хүндэт харилцагчид, хувьцаа эзэмшигчид, түнш байгууллагууд та бүхэндээ “Инвекор ББСБ” ХК-ийн анхны **“Байгаль орчин, нийгэм, засаглалын тайлан”**-г танилцуулж буйдаа баяртай байна.

Бид 2023 онд Байгаль орчин, нийгэм, засаглалын бодлого, тогтолцооны хэрэгжилтийг бизнесийн болон дотоод үйл ажиллагаандаа нэвтрүүлэхэд гол хүчин чармайлтаа чиглүүлэн ажиллалаа.

“Инвекор ББСБ” ХК нь байгууллагын дунд хугацааны стратеги, зорилгуудын нэгээр тогтвортой санхүүжилтийн чиглэлээр тэргүүлэх, тогтвортой санхүүжилтийн эх үүсвэрийг татах замаар Монгол улсын бичил санхүүгийн зах зээл дэх харилцагчдад санхүүжилт олгох зорилгыг тавьж ажилласан ба энэхүү зорилгын хүрээнд НҮБ-ын Даян Дэлхийн гэрээ, Partnership for Carbon Accounting Financial (PCAF) зэрэг олон улсын санаачилгуудад нэгдэн үүрэг амлалт хүлээн, хамтын ажиллагаагаа амжилттай өргөжүүллээ.

Түүнчлэн, бид хамтран ажилладаг олон улсын түнш байгууллагуудын шаардлага болон банк бус санхүүгийн салбарын онцлогтой уялдуулан Байгаль орчин, нийгмийн эрсдэлийн удирдлагыг зээлийн үйл ажиллагаандаа нэвтрүүлж харилцагчийн байгаль орчин, нийгэмд үзүүлэх сөрөг нөлөөллийг таньж мэдэх, үнэлэх боломжийг бүрдүүлэн ажиллаж байна.

“Инвекор ББСБ” ХК нь харилцагчдынхаа бизнесийн үйл ажиллагаанаас гадна өөрсдийн дотоод үйл ажиллагааг байгаль орчин, нийгэмд ээлтэйгээр явуулах, цаашлаад нийт ажилтнууддаа байгаль орчин, нийгэм, сайн засаглалын талаарх мэдлэг ойлголтыг түгээн дэлгэрүүлэх, ажилтнуудынхаа оролцоог нэмэгдүүлэх зорилгоор БОН ажлын хэсгүүдийг байгуулсан нь БОНЗ-ын бодлогыг байгууллагын бүхий л түвшинд хэрэгжүүлэн ажиллахад чухал түлхэц болсон.

“Инвекор ББСБ” ХК нь банк бус санхүүгийн салбарын зээлийн хүүг бууруулахад чухал хувь нэмэр оруулснаас гадна харилцагчийг хамгаалах бодлогын хүрээнд зээлийн шимтгэлийн тааз хэмжээг анх тогтоосон билээ. Цаашид бид харилцагчдынхаа хариуцлагатай, найдвартай санхүүжүүлэгч байх зорилгоо баримтлан тогтвортой хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлэх замаар тасралтгүй хөгжиж, шинийг эрэлхийлж ажиллахыг зорьж байна.

Бид тогтвортой хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлэхэд манлайлан ажиллаж, тогтвортой ногоон ирээдүйг харилцагчид, ажилтнууд, хамтрагч түншүүдтэйгээ хамтдаа бүтээж чадна гэдэгт итгэлтэй байна.

Д.Баясгалан

Гүйцэтгэх захирал



2023 оны гол үр дүнгүүд



90%

Байгаль орчин, нийгэм, засаглалын чиглэлээрх сургалтад давхардсан тоогоор нийт 250 гаруй ажилтан буюу байгууллагын нийт ажилтны 90 хувийг хамруулав.



1,305

Нийт 1305 харилцагчийн 208 орчим тэрбум төгрөгийн багц бүхий бизнесийн зээлийн хүсэлтэд БОН эрсдэлийн үнэлгээг хийв.



311

Өндөр эрсдэл бүхий 311 харилцагчийн 74 орчим тэрбум төгрөгийн зээлийн хүсэлтэд БОН эрсдэлийг бууруулах нарийвчилсан үнэлгээг хийж дүгнэлт гарган, холбогдох зөвлөмжийг өгч ажилласан байна.



100%

Нийт 41 харилцагчийн гомдол хүлээн авсан бөгөөд байгууллагын санал, гомдол шийдвэрлэх журмын дагуу стандарт хугацаанд багтаан харилцагчийн гомдлыг 100% шийдвэрлэн, хариу өгч ажилласан.



64%

2023 оны байдлаар бид нийт 175 ЖДҮ эрхлэгчдийн бизнест санхүүжилт олгосон бөгөөд үүний 112 нь буюу 64% -ийг эмэгтэй бизнес эрхлэгчид эзэлж байна.



66%

2023 онд нийт ажилтны 66% буюу 125 ажилтны цалинг нэмэгдүүлэв.



100%

Нийт ажилтнуудыг хувийн эрүүл мэндийн даатгалд 100% хамруулав.



3,000ш

Цаасан аяганы хэрэглээнээс татгалзав.



БОНЗ он цагийн хэлхээ



Хамтын ажиллагаа



“Инвескор ББСБ” ХК нь тогтвортой хөгжил болон байгаль орчин, нийгэм, засаглалын чиглэлээр дотоодын болон олон улсын нэр хүндтэй байгууллагуудтай хамтран ажиллаж, энэ чиглэлээр хувь нэмрээ оруулах үүрэг амлалт хүлээн банк бус санхүүгийн салбарт манлайлж, үйл ажиллагаагаа ил тод тайлагнан хамтран ажиллаж байна.



United Nations
Global Compact



PCAF Partnership for
Carbon Accounting
Financials



European Bank
for Reconstruction and Development



Ил тод байдал ба тайлагнал

Бид 2023 онд Монголын хөрөнгийн бирж (МХБ)-ийн “Үнэт цаас гаргагчаас олон нийтэд хүргэх мэдээллийн журам”-ын дагуу сайн дураар Байгаль орчин, нийгэм, засаглалын үйл ажиллагааны тайланг бэлтгэн МХБ-ын вэбсайтад олон нийтэд ил тод, нээлттэй байршууллаа.

Үүнээс гадна, дотоодын болон олон улсын хамтран ажилладаг, санхүүжүүлэгч байгууллагуудад засаглал, БОН эрсдэлийн менежментийн удирдлага, мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагааны гүйцэтгэлийн талаарх мэдээллийг тогтмол давтамжтайгаар хүргүүлэх үүргээ биелүүлэн ажиллаж байна.



БОНЗ бүтэц



Бид байгууллагын бүхий л түвшинд тогтвортой байдлын асуудлаарх үүрэг, хариуцлагыг дараах байдлаар тодорхойлон, БОНЗ бодлогодоо тусган хэрэгжүүлж байна.

Тогтвортой байдлын хороо

Байгууллагын алсын хараа, стратеги, үнэт зүйл, олон улсын тэргүүн туршлага, чиг хандлагад нийцүүлэн БОНЗ бодлогыг тодорхойлох, батлах, сайжруулах

Эрсдэлийн удирдлага хариуцсан нэгж

БОН эрсдэлийн удирдлагатай холбоотой бодлого, журмыг боловсруулах, шинэчлэх, БОН эрсдэлийн үнэлгээний арга аргачлалыг боловсруулах, шаардлагатай сургалт таниулах үйл ажиллагааг зохион байгуулах, БОН эрсдэлийн удирдлагын чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээний гүйцэтгэлийг хянах, нэгтгэн тайлагнах

Гүйцэтгэх удирдлага

БОН-ийн хүрээнд хүрэх зорилго, зорилтуудыг тодорхойлох, тэдгээрт хүрэх үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах, гүйцэтгэлийг үнэлэх, БОН-ийн талаарх аливаа асуудал, санал санаачилгуудыг хэлэлцэх, шийдвэрлэх

БОН ажлын хэсэг

Дотоод үйл ажиллагаанаас хамаарах БОН эрсдэл удирдах, өөрийн хариуцсан чиглэлээр шинэ санал санаачилга гаргах, нэвтрүүлэх, ажилтнуудад холбогдох сургалт, танин мэдүүлэх, нөлөөлөл үзүүлэх үйл ажиллагааг идэвхтэй зохион байгуулах.

БОН гомдол шийдвэрлэх механизм

"Инвескор ББСБ" ХК -ын санхүүжүүлсэн аливаа төслөөс үүдэн байгаль орчин, нийгэмд хохирол учруулсан эсхүл учруулах боломжтой гэж үзэж буй иргэд, байгууллага, бүлэг хүмүүсийн гомдлыг хүлээн авч шийдвэрлэх, дахин гарахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэн ажиллаж байна.

Ёс зүй ба комплаенс



“Инвекор ББСБ” ХК нь алсын хараа, баримтлах стратеги, үнэт зүйлийн хүрээнд санхүүгийн салбар, тэр дундаа банк бус санхүүгийн салбарт сайн засаглал, комплаенсын тэргүүн туршлага, бизнесийн ёс зүйн өндөр хэм хэмжээг баримтлан ажиллахыг эрмэлздэг.



Комплаенсын удирдлага

“Инвекор ББСБ” ХК нь Комплаенсын удирдлагын тогтолцооны хүрээнд байгууллагынхаа үйл ажиллагааг хууль тогтоомж, зохицуулагч байгууллагын дүрэм журамд нийцүүлэн ажиллахын зэрэгцээ олон улсын стандарт, сайн туршлагуудыг үйл ажиллагаандаа нэвтрүүлэн харилцагчдадаа санхүүгийн үнэ цэнтэй, урт хугацааны, эрсдэлгүй үйлчилгээг үзүүлэхийг зорин ажилладаг.

Үүний хүрээнд комплаенсын тогтолцоо, түүнд оролцогч талуудын хариуцлага, чиг үүргийг оновчлон тодорхойлж, Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх бодлого, журам, дотоод хяналтын хөтөлбөрийг хуульд дүрэмд нийцүүлэн хэрэгжүүлж байна.



Ёс зүй

Бид ёс зүйн болон ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, бизнесийн шударга байдлыг баримтлах замаар бизнесийн ёс зүйг эрхэмлэн ажилладаг.


Түүнчлэн нийт ажилтнуудын өдөр тутмын үйл ажиллагаанд баримтлах зарчим, ёс зүйн хэм хэмжээг тодорхойлон хэвшүүлэх, дагаж мөрдөх болон ёс зүйн зөрчилтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулах “Ажилтны ёс зүйн дүрэм” болон “Бизнесийн ёс зүйн дүрэм”-ийг ТУЗ-өөр батлуулан үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.



Шүгэл үлээх

Бизнесийн болон Ажилтны ёс зүйн дүрэм, холбогдох дотоод дүрэм журмыг зөрчсөн аливаа үйлдлийг таслан зогсоох, түүнийг мэдээлэх, байгууллага, харилцагч болон ажилтанд учирч болох эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилго бүхий шүгэл үлээх процессыг “Шүгэл үлээх журам”-аар зохицуулан шийдвэрлэж байна.

Шүгэл үлээгчийн мэдээллийн аюулгүй байдлыг хангах, мэдээллийг баталгаажуулах, шалгах, шийдвэр гаргах процессыг хараат бус байдлаар хийх, шаардлагатай асуудлыг Ёс зүйн хороонд уламжлан шийдүүлэх зэргээр процесс дэх чиг үүрэг, хариуцлагыг тодорхой журамлан, түүнийг хэрэгжүүлэн ажилладаг.




БОНЗ бодлого



"Инвескор ББСБ" ХК нь 2021 онд Байгаль орчин, нийгмийн бодлогоо баталсан бөгөөд байгууллагын бизнесийн үйл ажиллагаа болон өөрийн харилцагчийн бизнесийн үйл ажиллагаанаас үүдэх байгаль орчин, нийгэмд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулахад баримтлах зарчим, дагаж мөрдөх шаардлага, тэдгээртэй холбоотой үүрэг, хариуцлагыг тодорхойлж, бодлогын хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Уг бодлого нь НҮБ-ын Тогтвортой хөгжлийн 17 зорилго, Даян дэлхийн гэрээний 4 бүлэгт 10 зарчим, ТоС холбооны 8 зарчим болон Олон улсын хамтрагч түнш байгууллагуудын БОНЗ шаардлагуудад нийцсэн бөгөөд хариуцлагатай бизнес эрхлэхэд баримтлах гол баримт бичгүүдийн нэг юм.



Байгаль орчин, нийгмийн эрсдэлийн удирдлага



Бид харилцагчдынхаа бизнесийн үйл ажиллагааг үнэлэх замаар байгаль орчин, нийгэмд сөрөг нөлөөлөл үүсгэх эсэхийг тодорхойлох, сөрөг үр дагавар үүсгэхээр бол түүнийг бууруулах арга хэмжээ авах, ноцтой хохирол учруулж болзошгүй бол тухайн үйл ажиллагааг санхүүжүүлэхээс татгалзах хүртэл шийдвэр гаргах цогц зарчмуудыг тусгасан Байгаль орчин, нийгмийн удирдлагын тогтолцоог бүрдүүлсэн.


Бид үндсэн системдээ бизнесийн зээлийн БОН эрсдэлийн анхан шатны үнэлгээг хийх үе шатыг автоматжуулан нэвтрүүлсэн нь бизнесийн бүх төрлийн зээл дээр БОН үнэлгээг ажилтны оролцоогүй, хараат бусаар, үр дүнтэй үнэлэх боломжийг бүрдүүлээд байна.

Өнгөрсөн хугацаанд нийт 1305 харилцагчийн 208 орчим тэрбум төгрөгийн багц бүхий зээлийн хүсэлтэд БОН эрсдэлийн анхан шатны үнэлгээг хийж тэдгээрээс өндөр эрсдэл бүхий 311 харилцагчийн 74 орчим тэрбум төгрөгийн зээлийн хүсэлтэд БОН нарийвчилсан үнэлгээг хийн дүгнэлт гаргаж, эрсдэлийг бууруулах зөвлөмжийг харилцагч нартаа хүргүүлэн ажилласан байна.

Сургалт, чадавх бүрдүүлэлт

Бид 2023 онд байгууллагын бүх түвшинд тогтвортой санхүүжилтийн суурь ойлголтыг бий болгох, БОНЗ-ын чиглэлээр хариуцсан нэгжийн ажилтнуудын ур чадварыг нэмэгдүүлэх зорилгоор ToC Холбооны цахим сургалт болон байгууллагын тусгайлсан дотоод сургалтуудад нийт ажилтнуудын 90 гаруй хувийг хамрууллаа.

Түүнчлэн БОНЗ-ын сургалтыг байгууллагын шинэ ажилтны сургалтын хөтөлбөрт оруулж, заавал судалсан байх сургалтуудын нэг болгосон.



БОН эрсдэлийн үнэлгээ

• 311

Харилцагчийн 74 орчим тэрбум төгрөгийн бизнесийн зээлд нарийвчилсан үнэлгээг хийв.

• 1,305

Харилцагчийн 208 орчим тэрбум бизнесийн зээлд БОН эрсдэлийн үнэлгээг хийв.

Цахим үйлчилгээ



“Инвескор ББСБ” ХК нь бичил санхүүгийн зах зээлд дэвшилтэт технологи, шинэлэг шуурхай үйлчилгээг нэвтрүүлж, харилцагчдынхаа санхүүгийн “хариуцлагатай дэмжигч” байх зорилготой үйл ажиллагаа явуулдаг.

Үүний хүрээнд 2023 онд цаасгүй, шинэлэг технологид суурилсан таблетын зээл болон Инвескор аппликейшнийг үйл ажиллагаандаа амжилттай нэвтрүүлээ.

Мөн бид нийт харилцагчдынхаа санхүүгийн хэрэгцээг хүртээмжтэй, эрх тэгш үйлчилгээгээр ханган ажиллахад хүчин чармайлт гарган ажиллаж байна.

Инвескор аппликейшнээр дамжуулан харилцагчийн зээлийн эрхийн хэмжээг тогтоох, зээлийн анхан шатны тооцооллыг хийж мэдэгдсэнээр харилцагчийн шийдвэр гаргалтыг цаг алдалгүй, үр дүнтэй болгож байгаа бөгөөд харилцагчийг салбарт ирж үйлчлүүлэх цаг хугацаа, автомашины хэрэглээг багасгах зэргээр байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулж, харилцагчдынхаа сэтгэл ханамжийг дээшлүүлэн ажиллаж байна.

Таблетын платформ нь хөдөлгөөнт борлуулалтыг дэмжих, харилцагчийн үйлчилгээг сайжруулах зорилготой бөгөөд харилцагчийн болон ажилтны цагийг хэмнэх, зээлийн процессыг хялбаршуулах зэрэг олон давуу талтай юм.

Харилцагчдын хүйсийн харьцаа:



Хүртээмжтэй санхүүжилт:




Rocket цахим зээлийн үйлчилгээ



Санхүүгийн үйлчилгээ авахад хүндрэлтэй байдаг иргэдэд Rocket аппликейшнээр дамжуулан орон зай үл хамааран үйлчилгээ үзүүлж, санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлж байна.

 **866,433** удаа
Зээл олголт - Орон нутагт



“Инвескор Хэтэвч ББСБ” ХХК нь зээлийг 100% цахимаар олгосноор 2023 онд байгаль орчин, нийгэмд дараах эерэг нөлөөллүүдийг үзүүлсэн үр дүнтэй байна.

 **2,032,383**
Цахим зээлийн тоо

 **8,129,532**
Хуудас цаас хэмнэсэн

 **37,721** тн
Нүүрстөрөгчийн ялгаруулалтыг бууруулсан

 **81,295** тн
Ус хэмнэсэн

Gsign буюу тоон гарын үсгээр гэрээ байгуулах

Хэрэглэгчтэй бичгээр байгуулах гэрээг тоон гарын үсгээр баталгаажуулснаар цаасны хэрэглээг бууруулаад зогсохгүй, зайлшгүй салбар, тооцооны төв рүү зорих хөдөлгөөн, цаашлаад нэгж хэрэглэгчийн экологийн ул мөрийг бууруулав.



Харилцагчийн үйлчилгээ



Бид харилцагчдадаа байгууллагын бүтээгдэхүүн, үйлчилгээний талаар үнэн зөв, бодит мэдээллээр хангахаас гадна харилцагчийг халамжлан, хүндэтгэн харилцаж, сэтгэл ханамжийг өндөр байлгахад үйл ажиллагааны бүхий л үе шатандаа анхаарч ажилладаг.



 **▲ 90%**

2023 онд харилцагчдаас авсан сэтгэл ханамжийн судалгааны үр дүн 90% буюу өмнөх жилтэй харьцуулахад 6.4%-аар өссөн байна.

Мөн 2023 онд харилцагчдад тав тухтай, цэвэр, тохилог орчныг бүрдүүлэхэд онцгой анхаарч ажилласан ба нийт 8 салбарын дотоод засвар, тохижилтыг стандартад нийцүүлэн шинэчилсэн. Түүнчлэн жирэмсэн, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй харилцагчдыг оочир дараалалгүйгээр үйлчлүүлэх цонхыг салбаруудад бий болголоо.









Гомдлын удирдлага

Харилцагчийн үйлчилгээний газар нь байгууллагын үзүүлж буй бүтээгдэхүүн, үйлчилгээтэй холбоотой санал хүсэлт, гомдлыг хүлээн авах мөн түүнийг шийдвэрлэх үйл ажиллагааг хариуцан ажилладаг ба харилцагчийн өргөдөл, гомдол нь гарсан алдаа, дутагдлыг засах, үйл ажиллагаагаа сайжруулах боломж гэж хүлээн авч холбогдох журмын дагуу харилцагчийн санал хүсэлтийг түргэн шуурхай шийдвэрлэх, залруулах болон уг гомдлыг дахин гаргахгүй байхыг эрмэлзэн ажилладаг.

Мөн харилцагчийн санал, хүсэлт, талархал, гомдлыг хүлээн авах, шийдвэрлэх үйл ажиллагаанд байгууллагын Гүйцэтгэх захирал, эрх бүхий албан тушаалтан, газар, нэгж, салбарын ажилтан бүр өндөр үүрэг оролцоотой байдаг.

2023 онд харилцагчдаас ирүүлсэн санал, гомдлын шийдвэрлэлтийн чанарыг тогтмол сайжруулах, харилцагчийн хүлээлгийн хугацааг бууруулах, анхны хандалтаар хүлээлтээс давсан үйлчилгээг үзүүлэхэд чиглэн ажилласан бөгөөд байгууллагын бүтээгдэхүүн, үйлчилгээ үзүүлэх ажлын чанарыг удирдах, хянах тогтолцооны ISO 9001 стандартыг дахин баталгаажууллаа.

<p>Санал хүсэлтийн тоо</p> <p> 2,227</p>	<p>Гомдлын тоо</p> <p> 41 90% ▼</p>
<p>Талархлын тоо</p> <p> 32 160% ▲</p>	<p>Гомдол шийдвэрлэсэн хувь</p> <p> 100%</p>
<p>Харилцагчийн сэтгэл ханамж</p> <p> 90% 6.4% ▲</p>	<p> Амжилттай дахин баталгаажууллаа.</p>

Нийгмийн хариуцлага



ЖДҮ эрхлэгчдэд зориулсан сургалт, хөтөлбөр



“Инвекор ББСБ” ХК нь зээлийн үйлчилгээ үзүүлэхээс гадна харилцагчдадаа санхүүгийн удирдлагын зөвлөгөө, мэдээллийг хүргүүлэн ажиллаж байна.

Мөн харилцагчийн бизнесийн бэрхшээл, зах зээлийн өрсөлдөөнийг тодорхойлж, борлуулалтыг нэмэгдүүлэх зорилгоор АНУ-ын Олон Улсын Хөгжлийн Агентлагийн Санхүүжилттэй Хөгжлийн Шийдэл ТББ-ын хэрэгжүүлж буй BEST хөтөлбөртэй хамтран сургалт, зөвлөх үйлчилгээ үзүүлж ажиллаж байна. Тус чадавхижуулах хөтөлбөрийг ЖДҮ эрхлэгч нарт зориулан “Бизнесийг хөгжүүлэх хурдасгуур хөтөлбөр” нэрийн дор нийт 5 удаа зохион байгууллаа.

БОНЗ мэргэжлийн зөвлөл



Бид ТоС Холбооны дэргэдэх ББСБ мэргэжлийн зөвлөлийн гишүүнээр 2021 онд элссэн бөгөөд сүүлийн жилүүдэд БОНЗ чиглэлээр идэвхтэй үйл ажиллагаа, төслийг зохион байгуулж ажилласан. БОНЗ-ийн эерэг хөгжлийг бий болгоход ганц бидний бус салбарын үүрэг оролцоо чухал ач холбогдолтой юм.

Бид салбартаа тогтвортой хөгжлөөр тэргүүлэгч ББСБ-ын хувьд ТоС Холбооны дэргэдэх ББСБ мэргэжлийн зөвлөлийн гишүүдэд зориулан БОНЗ чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, өөрсдийн сайн туршлагаасаа хуваалцлаа.

Тэрбум мод үндэсний хөдөлгөөн



“Инвекор ББСБ” ХК нийгмийн хариуцлагын хүрээнд цөлжилт, газрын доройтлыг бууруулан, хүлэмжийн хийн шингээлт, ойн санг нэмэгдүүлэх зорилгоор Монгол улсын ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнд нэгдсэн.

Энэхүү хөтөлбөрийн хүрээнд бид 2030 он гэхэд 1 сая мод тарих амлалтыг өгсөн бөгөөд одоогийн байдлаар 781 мод тарьсан байна.

Тогтвортой хөгжлийн төлөөх үндэсний чуулган



2023 оны 9 сард Эдийн засаг, хөгжлийн яам болон НҮБ-ын Суурин зохицуулагчийн газрын хамтран зохион байгуулсан “Тогтвортой хөгжлийн төлөөх үндэсний чуулган”-ыг дэмжин оролцож, чуулганы үеэр ТХЗ-ын чиглэлээрх бодлого, хэрэгжүүлсэн үйл ажиллагаа, шинэ санал санаачилга, сайн туршлагаасаа хуваалцлаа.

Хувийн хэвшлийн байгууллагууд ТХЗ-ыг хэрэгжүүлэхэд ихээхэн үүрэг оролцоотой байдаг бөгөөд энэхүү чуулганаар дамжуулан тогтвортой хөгжлийн чиглэлээр манлайлан ажиллаж буй үндэсний компаниудтай туршлага солилцох, нийгэм болон байгаль орчиндоо ээлтэй үйл ажиллагаа эрхлэхийг уриалан дуудлаа.

Жендерийн эрх тэгш байдал



“Инвескор ББСБ” ХК нь нийгэмд тулгарч буй тэгш бус байдал, олон талт ялгаатай байдлыг ойлгож жендерийн мэдрэмжтэй байгууллага байхыг эрмэлздэг бөгөөд 2022 онд үйл ажиллагаа болон бүтээгдэхүүн, үйлчилгээний хүрээнд жендерийн эрх тэгш байдлыг хангахтай холбоотой баримтлах зарчмууд, бүтэц тогтолцоо, үүрэг хариуцлагыг тодорхойлох зорилготой “Жендерийн эрх тэгш байдлын бодлого”-ыг шинээр боловсруулан ТУЗ-өөр батлуулсан.

Шинэ ажилтнуудыг чадавхжуулах сургалтад “Жендерийн эрх тэгш байдлын бодлого”-ын сургалтын хөтөлбөрийг багтаасан байдаг. Мөн байгууллага нь ажлын байрны бэлгийн дарамт, ялгаварлан гадуурхалт, олон талт ялгаатай байдлыг үл зөвшөөрөх зэрэг асуудлуудыг нэн чухалчилж үздэг төдийгүй “Ажилтны ёс зүйн дүрэм”, “Шүгэл үлээх журам” болон “Жендерийн эрх тэгш байдлын бодлого”-уудад тус тус тусган, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.



Эмэгтэй ахлах ажилтнуудад зориулсан менторшип хөтөлбөр



2023 онд Жендерийн эрх тэгш байдлын багаас салбарын эмэгтэй зээлийн ахлах эдийн засагчдын ур чадвар, мэргэжлийн мэдлэг, карьерын хөгжилд дэмжлэг үзүүлэх зорилгоор Менторшип хөтөлбөрийг зохион байгуулсан. Нийт зээлийн ахлах эдийн засагчдын дунд явуулсан судалгаагаар дутагдаад буй ур чадварыг түлхүү хөгжүүлэх зорилгоор гаднын сургалтууд, менторын ганцаарчилсан уулзалтууд болон ментийнүүд хоорондоо туршлага солилцох арга хэмжээнүүдийг зохион байгууллаа.



Менторшип хөтөлбөрт оролцож, сургалтад хамрагдаад зөвлөгөө авсандаа маш их баяртай байна. Хувь хүн болоод карьер, ажил амьдралын балансаа тэнцвэртэй авч явахад сургалтууд болон ментортойгоо хийсэн хэд хэдэн уулзалт өөртэйгөө ажиллах, болж буй зүйлийг нэг тунгаах, эргэцүүлэн бодох, өөрчлөлт хийх урам зоригийг өгсөн.

Г.Болор-эрдэнэ

Энхтайван салбарын зээлийн ахлах эдийн засагч



Удирдлагын сэтгэлгээний онцлог, компани болон хувь хүний алсын хараа зэрэг олон сэдвээр нээлттэй бодол санаа, туршлагаа хуваалцсан Ментортоо маш их баярлалаа. Хөтөлбөрийн хүрээнд шинэ ойлголт, хөгжүүлэх сайжрах зүйл их байгааг ойлгосон бөгөөд оролцох боломжийг олгосонд талархлаа илэрхийлье!

Н.Батчимэг

Их Монгол салбарын зээлийн ахлах эдийн засагч

Эмэгтэй бизнес эрхлэгчдийг дэмжих зээл



“Инвескор ББСБ” ХК нь 2021 оноос эхлэн Рио Тинто Монгол ХХК-тай хамтран ЖДҮ эрхлэгчдэд зориулсан хөнгөлөлттэй зээлийн бүтээгдэхүүнийг зах зээлд нэвтрүүлсэн.

Бид нийгэмд тулгарч буй жендерийн тэгш бус байдлыг бууруулах, хүртээмжтэй санхүүжилтийг цогцлоох зорилгоор эмэгтэй гүйцэтгэх удирдлагатай болон эмэгтэй ажилтан давамгайлсан бизнес, аж ахуйн нэгжүүдэд уян хатан нөхцөлтэй зээлийн бүтээгдэхүүнийг санал болгож ажилласан.

2023 онд, ББСБ нь эмэгтэй бизнес эрхлэгчдийн бизнесийн үйл ажиллагааны үр ашгийг нь нэмэгдүүлэх зорилгоор бизнесийн бэрхшээлийг тодорхойлох, зах зээлийн өрсөлдөөнийг тодорхойлж борлуулалтыг нэмэгдүүлэх чиглэлээр 2 сарын хугацаатай цогц сургалтуудыг зохион байгууллаа.

Уг сургалт, хөтөлбөрийг АНУ-ын Олон улсын хөгжлийн агентлагийн санхүүжилттэй Хөгжлийн шийдэл ТББ-ын Best хөтөлбөртэй хамтран 4 удаа зохион байгуулсан бөгөөд нийт 73 эмэгтэй ЖДҮ эрхлэгчид хамрагдаад байна.

Санхүүжилт олгосон ЖДҮ эрхлэгчдийн хүйсийн харьцаа



Дэмжсэн эмэгтэй бизнес эрхлэгчдийн бизнесийн чиглэл

Оёдол	43
Арьс, ширэн бүтээгдэхүүн	16
Хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэл	11
Эмнэлэг	7
Мод, модон эдлэл	5
Гоо сайхан	5
Барилгын материал үйлдвэрлэл	5
Бусад	20



Харилцагчийн сэтгэгдэл

Миний хувьд 2020 оноос анх саван, лаа, банны бөмбөлөг гэх мэт биеийн арьс арчилгааны бүтээгдэхүүнийг үйлдвэрлэж эхэлсэн бөгөөд одоо JoJo Felt (Жожо Фэлт) эсгий бүтээгдэхүүний үйлдвэрлэл эрхэлж байна. Энэ бүхнийг эхлэхэд надад хөрөнгө мөнгө гэж зүйл огт байгаагүй. Хүн дуртай л байх юм бол жижгээс эхэлж болдог. Миний хувьд бага багаар, шат шатаар үйл ажиллагааны чанараа тогтвортой сайжруулж явсаар хийх зүйл яг тодорхой болох үед “Инвескор ББСБ” ХК болон “Рио Тинто Монгол” ХХК-ийн хамтарсан ЖДҮ эрхлэгчдийг дэмжих хөтөлбөрөөс санхүүжилт авч тоног төхөөрөмж худалдан аваад зогсохгүй бизнесийн үйл ажиллагаандаа шинэчлэлт хийж чадсандаа баяртай байна.

Ногоон оффис



Тав тухтай ажиллах орчин

Хаяг байршил	14 давхар, IC Тауэр, Парисын гудамж, 1 хороо, СБД, Улаанбаатар хот
Газар хөдлөлтийн тэсвэрлэлт:	8 балл
Давхрын тоо:	16 давхар
Барилгын нийт талбай:	15,000м ²
Инвескор ББСБ-ын эзэмшлийн талбай:	720м ²
Зогсоолын тоо:	107ш дулаан зогсоол

Оффисын орчинд агаар сэлгэлтийн болон агаар цэвэршүүлэх төхөөрөмжүүдийг суурилуулсан ба ажилтанд амрах зориулалттай 3 өрөө, утсаар ярих зориулалттай 4 өрөөг тус бүр зориулалтын дагуу тохижуулсан байна.

Оффисын 4 давхарт ногоон байгууламж бүхий ажилтнуудын чөлөөт цагаа өнгөрөөх террасстай.

Мөн ажилтнуудад үдийн хоолоо идэх, кофе, цай бэлдэх тоног төхөөрөмж, орон зайг тусгайлан бэлдэж өгсөн.



2023 оны нөөцийн хэрэглээ




Хариуцлагатай хэрэглээ

“Инвескор ББСБ” ХК нь өөрийн дотоод үйл ажиллагаандаа байгаль орчин, нийгэмд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулж ажиллахыг эрмэлздэг бөгөөд худалдан авах үйл ажиллагаандаа тогтвортой бөгөөд хариуцлагатай худалдан авалтын зарчмыг хэрэгжүүлэн ажилладаг. Энэхүү зарчмын хүрээнд, худалдан авах шийдвэр гаргалтад БОН-д үзүүлэх нөлөөллийг харгалзан үзэхээс гадна үндэсний үйлдвэрлэгч, эмэгтэй бизнес эрхлэгч болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжих худалдан авалт хийхийг зорьж байна.

Нийт ажилтнуудыг хамарсан үйл ажиллагааны үеэр ашиглагддаг цаасан аяганы хэрэглээг халах зорилгоор “Хуванцар хэрэглээг багасгасан COOL ажилтан” гэсэн уриа бүхий tumbler аягыг нийт ажилтнууддаа олгов.

Ингэснээр 2023 онд нийт 3000 ширхэг нэг удаагийн аяганаас татгалзаж, олон нийтийн үйл ажиллагааны үеэр гардаг хог хаягдлын хэмжээг 5 дахин бууруулж чадлаа.

Түүнчлэн ажилтнуудад хог хаягдлын менежмент, ус, эрчим хүчний хариуцлагатай хэрэглээг төлөвшүүлэх ач холбогдлыг таниулах сургалт, мэдээллийг тогтмол хүргэж БОНЗ-ын соёлыг өдөр тутмын үйл ажиллагаандаа хэвшил болгохыг зорин ажиллаж байна.



Ажилтнуудын сэтгэл ханамж ба эрүүл мэнд



“Инвескор ББСБ” ХК нь тогтвортой ажиллах хүчийг тогтвортой бизнесийн хөгжлийн үндэс суурь гэж үзэн ажилтнуудынхаа эрүүл мэнд, сэтгэл зүй болон ажил, амьдралын тэнцвэрт байдлыг хадгалахад онцгой анхаарал хандуулдаг.

Өмнөх онтой харьцуулахад 2023 онд ажилтнуудын сэтгэл ханамжийн түвшнийг 1%-аар нэмэгдүүлэн ажилласан бөгөөд бид ажилтнуудынхаа сэтгэл ханамж, ажиллах хүсэл эрмэлзлийг нэмэгдүүлэхийн тулд байгууллагын зүгээс олон төрлийн хөнгөлөлт, хангамжийг олгож байна.

 **▲1%**

Ажилтнуудын сэтгэл ханамжийн өсөлт

 **192**

Ажилтан эрүүл мэндийн бүрэн даатгалд хамрагдсан байна

 **150**

Ажилтан жил тутмын эрүүл мэндийн урьдчилсан үзлэгт хамрагдсан байна

Хөнгөлөлт, хангамжууд

-  Ажилтны хувийн эрүүл мэндийн даатгал
-  Мэргэжлийн сэтгэл зүйчийн зөвлөгөө
-  Уян хатан ажлын цаг
-  Спортын хөнгөлөлт, урамшуулал
-  Эрэгтэй ажилтнуудад зориулсан эрүүл мэндийн цалинтай чөлөө
-  Ажилтнуудад зориулсан сургалт, хөгжлийн хөтөлбөрүүд
-  Ажилтны унаа, утасны хөнгөлөлт
-  Ажилтан гэрлэх ёслол хийж буй тохиолдолд 3 хүртэлх өдрийн цалинтай чөлөө

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэнд


“Инвескор ББСБ” ХК нь хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль тогтоомжийн дагуу ажилтнуудыг эрүүл, аюулгүй орчинд ажиллах нөхцөлөөр хангах, хөдөлмөрийн аюулгүй байдлын хэрэгжилтийг хангах зорилгоор “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн журам”-ыг батлан үйл ажиллагаандаа баримтлан ажиллаж байна.

Мөн ХАБЭА зөвлөл болон үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх комиссыг байгуулан ХАБЭА-тай холбоотой асуудлыг удирдлагын түвшинд тухай бүр бүрэн шийдвэрлэж байна.

Эрүүл мэнд

2023 онд бид ажилтнуудынхаа ажил, амьдралын тэнцвэрт байдлыг хангах, амралт чөлөөт цагийг үр бүтээлтэй өнгөрүүлэх, тэдний сэтгэл зүйн болон биеийн эрүүл мэндэд анхаарахад чиглэсэн арга хэмжээ, үйл ажиллагаануудыг нийт ажилтнуудын дунд нээлттэй зохион байгуулж, амжилттай хэрэгжүүлэн ажиллалаа.

Мөн бид ажилтнуудынхаа сэтгэл зүйн эрүүл мэндийг онцгойлон анхаарч ажиллаж байгаа бөгөөд нийт ажилтнуудын сэтгэл зүйн эрүүл мэндэд үнэлгээ хийж, сэтгэл зүйн зөвлөгөө өгөх, сэтгэл зүйн боловсрол олгох зорилгоор туршлагатай сэтгэл засалч ажиллуулж байна.



Сэтгэл зүйн зөвлөгөө авах ерөө

Мэдээллийн аюулгүй байдал



“Инвескор ББСБ” ХК нь байгууллагын эрсдэлийн удирдлагын тогтолцооны хүрээнд мэдээлэл аюулгүй байдлын эрсдэлүүдийг урьдчилан тодорхойлж, эрсдэлийг бууруулах арга хэмжээг авч хэрэгжүүлэн ажиллаж байна.

ISO/IEC 27001 нь мэдээллийн аюулгүй байдлын удирдлагын тогтолцоог бий болгох, хэрэгжүүлэх, хэвийн үргэлжлүүлэх, тасралтгүй сайжруулахад чиглэсэн стандарт бөгөөд байгууллагын эзэмшдэг мэдээллийн хөрөнгийг найдвартай, аюулгүй бүрэн бүтэн байлгахыг зорьдог.

2023 онд бид Канад улсад төвтэй MSECBC олон улсын аудитын байгууллагаар мэдээллийн аюулгүй байдлыг хангах ISO27001:2013 олон улсын стандартын хэрэгжилтэд аудит хийлгэн, дахин баталгаажуулалт авснаар мэдээллийн аюулгүй байдлын стандартыг үр дүнтэй хэрэгжүүлж буйгаа дахин батлалаа.



Тогтвортой хөгжилд Инвескор 2023



<p>3 ЗРҮҮЛ МЭНДИЙГ ДЭМЖИХ</p> 	<p>4 ЧАНАРТАЙ БОЛОВСРОЛЫГ ДЭМЖИХ</p> 	<p>5 ЖЕНДЕРИЙН ЭРХ ТЭГШ БАЙДЛЫГ ХАНГАХ</p> 	<p>8 ЗОХИСТОЙ ХӨДӨЛМӨР БА ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТИЙГ ДЭМЖИХ</p> 	<p>9 ИНОВАЦИ БОЛОН ДЭД БҮТЦИЙГ ХӨГЖҮҮЛЭХ</p> 
<p>10 ТЭГШ БУС БАЙДЛЫГ БУУРУУЛАХ</p> 	<p>12 ХАРИУЦЛАГАТАЙ ХЭРЭГЛЭЭГ ДЭМЖИХ</p> 	<p>13 УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН ҮР НӨЛӨӨГ БАГАСГАХ</p> 	<p>16 ЭНХ ТАЙВАН, ШУДАРГА ЁСЫГ ЦОГЦЛООХ</p> 	<p>17 ХӨГЖЛИЙН ТӨЛӨӨХ ТҮНШЛЭЛИЙГ БЭХЖҮҮЛЭХ</p> 

Тогтвортой хөгжлийн алсын хараа



Тогтвортой
санхүүжилт



Уур амьсгалын
эрсдэлийн
удирдлага



Жендерийн эрх
тэгш байдал



Ил тод
тайлагнал



Үлгэрлэн
манлайлал





Тогтвортой хөгжлийг түүчээлэгч

Холбоо барих

14th Floor, IC Tower,
Paris street-42, Sukhbaatar district-1,
Ulaanbaatar, 14251

Tel. +976-7709-0077
info@invescore.mn
www.invescore.mn